



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 511

Улаанбаатар хот

“МИК Актив Нэг” ХХК-д
тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.6, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6.2, 6.3 дахь заалтууд болон Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “МИК Актив Нэг” ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрлийг тус компанийн гаргаж буй орон сууцны хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төлбөрийг гүйцэтгэх эцсийн хугацаанаас багагүй хугацаагаар олгосугай.

2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.5-д заасны дагуу энэхүү тогтоолын 1-д заасан тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны төрөл болон оноосон нэрэндээ өөрчлөлт оруулж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн энэ тухай Санхүүгийн зохицуулах хороонд эргэн мэдэгдэхийг “МИК Актив Нэг” ХХК-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000865